



ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТӨВ, ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ХООРОНДЫН ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2025 оны 12 дугаар сарын 11-ны өдөр

Дугаар 25/Б

Улаанбаатар хот

Энэхүү хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг /цаашид "Санамж бичиг" гэх/-ийг нэг талаас "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТҮГ, түүнийг төлөөлж Төвийн захирал М.Амгаланбаатар /цаашид "ТХХТТ" гэх/ нөгөө талаас Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар, түүнийг төлөөлж Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатар /цаашид "ЗДТГ" гэх/, бид /цаашид тусад нь "Тал", хамтад нь "Талууд" гэх/ хооронд хоёр байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор харилцан тохиролцож энэхүү "Санамж бичиг"-ийг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Санамж бичгийн зорилго нь ТХХТТ болон Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.
- 1.2 Санамж бичиг нь Талуудын дагаж мөрдөж буй аливаа дүрэм, журамд нийцсэн бөгөөд санамж бичиг байгуулах болсон үндэслэл, шалтгаан нөхцлийн талаар талууд бүрэн ойлголцсон болно.
- 1.3 Талууд хамтын ажиллагаандаа хууль дээдлэх, хоорондын харилцааны зохистой хэм хэмжээг баримтлан харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэн, нээлттэй, ил тод байх, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмуудыг баримтлана.
- 1.4 Энэхүү санамж бичиг нь Талууд цаашдын харилцааны үндсэн баримт бичиг болох бөгөөд хууль эрх зүйн болон санхүүгийн аливаа үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

ХОЁР.ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 2.1 Санамж бичгийн хүрээнд дараах чиглэлээр хамтран ажиллана.
 - 2.1.1 Хөвсгөл аймгийн Засаг даргын "Бүтээлч Хөвсгөлчүүд 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Түншлэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төр болон хувийн хэвшил хоорондын үр дүнтэй, тогтвортой түншлэлийг хэрэгжүүлж, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
 - 2.1.2 Хөвсгөл аймагт Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангахад Түншлэлийн төвөөс дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах.
 - 2.1.3 Түншлэгч талуудад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.
 - 2.1.4 Хөрөнгө оруулагч болон бусад сонирхогч талуудад зориулсан мэдээлэл танилцуулга хийх.

2.1.5 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухайн хуулийн 19 дүгээр зүйл, 20 дугаар зүйлд заасны дагуу төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ, санхүүгийн тооцоолололд зөвлөх үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тухай бүр гэрээ байгуулан ажиллах.

2.1.6 Сургалт зохион байгуулах.

2.2 Талууд санамж бичгийн хүрээнд харилцан тохиролцсоны үндсэн дээр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хариуцах нэгж, ажилтнуудыг томилон ажиллуулах ба хэрэгжилтийг жил тутам дүгнэнэ.

ГУРАВ.БУСАД

3.1 Санамж бичиг нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 2 /хоёр/ жилийн хугацаанд хүчинтэй байна.

3.2 Талууд Санамж бичигт харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Санамж бичгийн адил хүчин төгөлдөр болно.

3.3 Санамж бичгийн хүрээнд харилцан солилцсон мэдээллийг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй байна.

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН
ТҮНШЛЭЛИЙН ТӨВ ТӨААТҮГ-ЫГ
ТӨЛӨӨЛЖ**


ЗАХИРАЛ М.АМГАЛАНБААТАР



...../гарын үсэг/

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

ЗАСАГ ДАРГА Л.ТӨМӨРБААТАР



...../гарын үсэг/